



**П.Н.ШАСТИНЫ НЭРЭМЖИТ
УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ**

Ард Аюушийн гудамж 1а, 5 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16081

Утас: (976) 7700 0304,

Цахим шуудан: tsch@shastinhospital.mn

Цахим хуудас: www.shastinhospital.mn

2024.06.24 № 01/688

танай _____ -ны № _____ -т

УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЭМНЭЛГИЙН ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ
ЭМЯ/20240102089 ДУГААРТАЙ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД
ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭД, ОРОЛЦОГЧ НАРТ

Гомдлын хариу хүргүүлэх тухай

Тус эмнэлгээс 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зарласан “Улсын гуравдугаар төв эмнэлгийн тоног төхөөрөмж/Улаанбаатар, Баянгол дүүрэг” нэртэй тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр захиалагчид гомдол ирүүлснийг Төрийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дүгээр зүйлийн 57.3-д заасны дагуу эмнэлгийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/97 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо хуралдан дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн III бүлэгт заасан Багц №1-ийн Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны аппаратын иж бүрдлийн техникийн тодорхойлолтыг хавсралтаар хүргүүлж байна.
2. Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны аппаратын иж бүрдэл нь Монгол улсад 1-2 ширхэг байдаг юм байна. Тус эмнэлгийн хувьд анх удаа холбогдох эмч, мэргэжилтнүүдийн удаа дараагийн хүсэлтийн дагуу энэхүү аппаратыг судалж авахаар төлөвлөн ажиллаж байгаа болно. Тус аппаратыг анх удаа худалдан авч байгаа учир туршлага, мэдээлэл дутмаг байгааг үгүйсгэхгүй юм.

Иймд тендер шалгаруулалтын баримт бичгийн II бүлэг, Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 25.5-д “Оролцогч нь Багц №1 Титэм судсан дотуурх хэт авиан оношилгооны иж бүрдэл аппаратыг нийлүүлэхдээ баталгаат хугацаанд холбогдох мэргэжлийн 2-3 эмч мэргэжилтнийг тухайн аппаратыг үйлдвэрлэгч улсад нь 7-14 хоногийн хугацаатай чадавхижуулах сургалтад хамруулах” гэж нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэн Төрийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дүгээр зүйлийн 57.4-д заасныг үндэслэн тендер шалгаруулалтыг үргэлжүүлэх шийдвэр гаргасныг үүгээр мэдээлж байна.

ЗАХИРАЛ, АНАГААХ УХААНЫ
ДОКТОР



Ц.ТӨМӨР-ОЧИР

160310300516